

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
БАТЧУЛУУН ОВОГТОЙ ОКТЯБРИЙН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: Иргэддээ ээлтэй Эрдэнэт хот

Энэхүү мөрийн хөтөлбөр нь 3 үндсэн чиглэлтэй болно.


- ✓ Эдийн засаг - Тогтвортой хөгжил
- ✓ Төрийн үйлчилгээ – Сайн засаглал
- ✓ Ногоон хөгжил - Эко Эрдэнэт хот

Эдийн засаг - Тогтвортой хөгжил : Эрдэнэт хотын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, бүсчилсэн хөгжлийн бодлогод уялдуулан бага дунд орлоготой иргэдэд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлэх замаар байнгын баталгаатай орлогын эх үүсвэр бий болгоход чиглэсэн бодлого баримтлан төр болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

Төрийн үйлчилгээ – Сайн засаглал : Төрийн үйлчилгээний чанрыг сайжруулж иргэдийн хэрэгцээнд суурилсан түргэн шуурхай уян хатан хүртээмжтэй иргэн төвтэй төрийн үйлчилгээг бий болгож засаглалыг хөгжүүлэхэд чиглэж ажиллана.

Ногоон хөгжил - Эко Эрдэнэт хот: Хүн амын суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хотын хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөг эко хотын жишигт нийцүүлэн иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилор орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлж байгальд ээлтэй ЭКО хотын бий болгоно.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан :

 Б.Октябрь

